



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 02 өдөр

Дугаар А/115

Булган сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1.6, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн малчин эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээ авах эрхийн хүрээнд тэднийг мэдлэг, мэдээллээр хангах арга хэмжээг хэрэгжүүлж, малчин эмэгтэйчүүдийнхээ хөдөлмөр зүтгэлийг үнэлэх, дэмжин урамшуулах олон нийтэд сурталчлах зорилгоор “Шинэ хөгжлийг түүчээлэгч шилдэг төлчин эмэгтэйчүүд” чуулга уулзалтыг зохион байгуулсугай.

2. Төлчин эмэгтэйчүүдийн чуулга уулзалтыг зохион байгуулахад шаардагдах 11,150,000 (арван нэгэн сая нэг зуун тавин мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын хөтөлбөр, төлөвлөгөө хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

3. Эмэгтэйчүүдийн чуулга уулзалтыг зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, заасан хугацаанд хурдан шуурхай зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (М.Батчимэг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2023 оны
03 дугаар сарын 02-ны өдрийн А/МС дугаар
захирамжийн хавсралт

ШИНЭ ХӨГЖЛИЙГ ТҮҮЧЭЭЛЭГЧ ШИЛДЭГ ТӨЛЧИН ЭМЭГТЭЙЧҮҮД
ЧУУЛГА УУЛЗАЛТ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСӨВ

Д/д	Шаардагдах зардал	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	2	3	4	5
1	Сарнай цэцэг	500 ш	5,000	2,500,000
2	Хүзүүний алчуур /ялгуун брэнд/	500 ш	30,000	15,000,000
3	Хэвлэлийн эх бэлтгэл	-	50,000	50,000
4	Өдрийн хоол	500 хүн	18,000	9,000,000
5	Зал, техник хэрэгсэл зөөх шатахуун	2 удаа	125,000	250,000
6	Ус, ундаа	500 ш	2,000	1,000,000
7	Сандал зөөх, шатахуун	2 удаа	125,000	250,000
8	Монголын эмэгтэйчүүдийн холбооны хүндэт тэмдэг	10 ш	50,000	500,000
9	Монголын залуучуудын холбооны тэргүүний залуу, хөдөлмөрийн алдар тэмдэг	10 ш	60,000	600,000
Нийт дүн			29.150.000	
Үүнээс:				
1. Аймгийн засаг даргын хөтөлбөр төсөл арга хэмжээний зардлаас – 11,150,000 (Чинээлэг малчин хөтөлбөр – 5,000,000), (Жендэр хөтөлбөр – 5,000,000), (Хөдөлмөр нийгмийн зөвшлийн гурван талт хэлэлцээр хөтөлбөр – 1,150,000)				
2. Булган хангай хөгжлийн төлөө сангаас – 15.000.000				
3. Орлогоос-3.000.000				